

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9.	Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12.	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал.....	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчийн үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРЭЭЛЭН ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
М.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

2020.03.13 № 06/820
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг захирал М.Түмэнжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн анхан шатны баримтын бүрдлийг хангах, зардлыг зөв тусгах, үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 24-нөөс 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Цэгцтөв богд аудит” ХХК-ийн аудитор Г.Цэцэгмаа, аудиторовн туслах Б. Баярмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ нь 2019 оны санхүүгийн тайланг “Цэгцтөв Богд Аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/52 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ нь “Хамтдаа Монгол улсын эрчим хүчний салбарын ирээдүйг тодорхойлох” гэсэн эрхэм зорилго болон “Эрчим хүчний салбарын ойрын болон дунд хугацаа, хэтийн хөгжлийн бодлого, стратеги боловсруулахад шаардагдах өгөгдөл цуглуулах, эрчим хүчний хэрэглээний таамаглал, эдийн засгийн тооцоо, судалгаа шинжилгээг шинжлэх ухааны үндэстэй боловсруулан гаргах, мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны материал, мэдээллээр эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг хангах, зураг төсөв боловсруулах, шинэ техник, технологийн судалж нэвтрүүлэх, нормативын бичиг баримтыг боловсронгуй болгох замаар эрчим хүчний салбарын хөгжлийг хангахад оршино.” гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажилладаг байна.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрчим хүчний салбарын зураг төсөл боловсруулах
- Эрчим хүчний судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 25 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 19 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгов.

Төрийн өмчит үйлдвэрийн газар орлого олох зорилготой тул материаллаг байдлын суурийг орлоготой уялдуулсан болно.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь тухайн байгууллагын аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдэлийг бага гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 1,831.3 сая төгрөгийн 2 хувь болох 36.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 636.4 сая төгрөгөөр буюу 21.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	277.4	263.4	(14.0)
Авлага	1,281.5	677.9	(603.6)
Бараа материал	53.4	73.4	20.0
Үндсэн хөрөнгө	1,311.2	1,272.4	(38.8)
Нийт хөрөнгө	2,923.5	2,287.1	(636.4)
Өр төлбөр	977.3	292.3	(685.0)
Эздийн өмч	1,946.2	1,994.8	48.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,923.5	2,287.1	(636.4)

Авлага дансны үлдэгдэл буурсан нь тусгай зөвшөөрлийн авлагаар бүртгэгдсэн 657.1 сая төгрөгийг тайлант хугацаанд барагдуулснаас шалтгаалсан. Авлага дансанд тусгай зөвшөөрлийн 262.3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн 0.3 сая, дансны авлага 412.7 сая, бусад холбоотой талуудаас авах 2.5 сая төгрөгийн авлага байна.

Дансны авлагад Эрчим хүчний яамны 89.1 сая, Эрчим хүчний хөгжлийн төвийн 79.1 сая, Алтай трест ХХК-ийн 108.8 сая, Эрчим хүчний барилга угсралт трейд ХХК-ийн 58.4 сая, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын 29.9 сая, ДЦС-3 ТӨҮГ-ын 16.8 сая, ДЦС-4 ТӨҮГ-ын 14.6 сая, бусад хуулийн этгээдээс авах 16.0 сая төгрөгийн авлага байна.

Үндсэн хөрөнгө Эрчим хүчний яамны 2019 оны Б/4531 тоот албан бичгийн дагуу балансаас балансад шилжүүлж авсан 5.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 7.1 сая төгрөгийн тавилга эд хогшил, 16.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийт 23.4 сая төгрөгийн хөрөнгө болон барилга байгууламжийн их засварын зардал 13.1 сая төгрөгийн капиталжуулалтаар нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 287 тоот тогтоолын дагуу 8.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Өр төлбөр дансанд тусгай зөвшөөрлийн урьдчилж орсон орлого 263.2 сая төгрөг, татварын өр 25.3 сая төгрөг нийт 288.5 сая төгрөг нь нийт өр төлбөрийн 98.7 хувийг эзэлж байна. Татварын төлбөрийг 2020 оны 1 дүгээр сард бүрэн төлж барагдуулсан бөгөөд урьдчилж орсон орлого дансанд бүртгэгдсэн орлого, тусгай зөвшөөрлийн авлага дансны бүртгэлийг залруулахыг зөвлөмжид тусгасан болно.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зорилтын саналыг, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Төрийн өмчит хуулийн этгээд дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасныг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 471 дугаар тогтоолоор Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ нь 2019 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг 1,769.5 сая төгрөгийн орлоготой, 1,765.3 сая төгрөгийн зардалтай, 4.2 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар баталжээ.

Тайлант онд гүйцэтгэлээр 1,824.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж батлагдсан төлөвлөгөөг 55.2 сая төгрөгөөр давуулсан байна. Энэ нь гадаадын хөрөнгө оруулалтаар төслийн ажил гүйцэтгэсэн болон тусгай зөвшөөрөл эзэмших эрх авах харилцагчдын тоо нэмэгдсэнээс шалтгаалсан болно.

Зардлын гүйцэтгэлээр нийт 1,728.0 сая төгрөгийг зарцуулж 96.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Зардлын хэмнэлт нь зорилтот түвшингээр батлагдсан ажилтны орон тоо нэмэгдүүлэх тушаал 2019 оны 5 дугаар сард гарсан тул энэ хугацаа хүртэлх нэмэгдсэн ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, унаа хоолны хөнгөлөлт, хамрагдах ёстой төлөвлөгөөт сургалтууд хийгдээгүйн улмаас төлөвлөгдсөн сургалтын зардал, үл хөдлөх эд хөрөнгийн дахин үнэлгээний жил бууруулж тогтоосноос хуримтлагдсан элэгдлийн зөрүү зэргээс шалтгаалсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 19 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 22 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 34.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7.4 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 27.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

Тухайн байгууллагын ажилтантай холбогдох шүүгчийн захирамжийн дагуу ажиллаагүй хугацаанд цалин олгож, түүнд ногдох НДШ-ийн төлбөрийг зардлаар тооцож хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зардлыг өсгөсөн нь “Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалт “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэсний аудитын газар шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

Аудитаар илэрсэн 27.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрчим хүчний сайдын тушаалаар эрчим хүчний байгууллагуудад тусгай зөвшөөрлийг олгож, тусгай зөвшөөрлийн хураамжийг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн дансанд төвлөрүүлдэг орлогоос байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээс гадна Эрчим хүчний яамны ажилтнуудын гадаад томилолт болон зочин хүлээн авах зардалд зарцуулж байгаа нь үйл ажиллагааны зардлыг буруу илэрхийлэхэд хүргэж байгаа нь дээд шатны байгууллага цаашид анхаарах чухал асуудал байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацааны дагуу байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 34.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 36.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тусгай зөвшөөрөл олгох тушаалыг үндэслэн анхан шатны баримтгүйгээр ажил гүйлгээг бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээ гарсан үед нь бүртгэх, өмнө бүртгэсэн авлагыг барагдуулах ажил зохион байгуулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах хариу ирүүлсэн.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Хүлээн авалтын зардлыг үйл ажиллагааны зардлаар тооцон татвар ногдуулах орлогыг 26.0 сая төгрөгөөр бууруулсан нь “ААНОАТ-ын хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь заалт ” Энэ хуулийн 8...-т заасан татвар ногдох орлогоос хуулийн 12 дугаар зүйлд заасан зардлыг хасч албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Татварын шалгалтаар алданги торгууль ногдох, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Татварын тайланг үнэн зөв тайлагнах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Холбогдох засварыг хийж цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Иргэнд олгосон ибаримтаар зардал бүртгэж үйл ажиллагааны зардлыг 1.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь "Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь заалт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, татварын шалгалтаар алданги торгууль ногдох, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тохиолдсон байх батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж, татварын тайланг үнэн зөв илэрхийлэх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Холбогдох засварыг хийж цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	277,383,166.53	263,444,107.73
1.1.2	Дансны авлага	306,054,629.73	5,760,847.73
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	24,330.36	301,985.79
1.1.4	Бусад авлага	975,432,815.01	264,817,088.91
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	53,420,396.83	73,396,269.35
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,612,315,338.46	1,014,695,876.51
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,019,498,039.83	1,001,961,377.64
1.2.2	Биет бус хөрөнгө	291,740,399.92	270,443,177.62
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,311,238,439.75	1,272,404,555.26
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,923,553,778.21	2,287,100,431.77
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	11,290,392.83	25,331,290.56
2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	963,419,176.00	263,167,135.35
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,823,900.00	1,745,209.80
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	976,533,468.83	290,243,635.71
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		

2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	727,154.06	2,057,808.61
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	727,154.06	2,057,808.61
2.2	Өр төлбөрийн нийт дүн	977,260,622.89	292,301,444.32
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	908,307,982.92	913,718,777.62
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	111,172,099.86	111,172,099.86
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	91,992,981.37	91,992,981.37
2.3.9	Хуримтлагдсан ашиг	834,820,091.17	877,915,128.60
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,946,293,155.32	1,994,798,987.45
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,923,553,778.21	2,287,100,431.77

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,822,514,329.03	1,815,469,943.64
2	Борлуулалтын өртөг	1,397,206.42	249,747,128.61
3	Нийт ашиг(алдагдал)	1,821,117,122.61	1,565,722,815.03
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	4,180,398.51	5,882,000.12
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,526,353,126.89	1,478,303,103.32
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	4,578,903.04	3,390,714.49
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	303,523,297.27	96,692,426.32
19	Орлогын татварын зардал	35,163,144.26	13,343,365.94
20	Татварын дараах ашиг (алдагдал)	268,360,153.01	83,349,060.38
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	268,360,153.01	83,349,060.38

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,943,271,178.15	1,797,559,388.97
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,852,137,280.67	1,737,438,712.64
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	7,755,761.00	17,384,671.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	83,378,136.48	42,736,005.33
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,583,585,306.34	1,747,688,408.94
1.2.1	Ажиллагчдад төлсөн	556,971,906.14	679,403,295.83
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	126,741,298.72	210,754,666.54
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	50,373,996.10	34,376,876.94
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	49,613,199.93	32,939,514.63
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	39,344,247.00	53,480,810.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	128,645,897.06	143,785,347.94
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	42,266,486.21	26,286,880.03
1.2.9	Бусад мөнгөн зарлага	589,628,275.18	566,661,017.03
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	359,685,871.81	49,870,980.03
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,180,398.51	5,882,000.12
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	4,180,398.51	5,882,000.12
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	213,555,587.00	36,588,016.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	156,665,587.00	36,588,016.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	15,000,000.00	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6	Бусад	41,890,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-209,375,188.49	-30,706,015.88

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Бусад		7,150,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	36,987,690.00	40,254,022.95
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	36,987,690.00	40,254,022.95
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-36,987,690.00	-33,104,022.95
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	113,322,993.32	-13,939,058.80
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	164,060,473.21	277,383,166.53
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	277,383,166.53	263,444,107.73

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12 дугаар сарын 31-	50,942,564.92	241,520,901.21	4,170,141.37	604,329,961.16	900,963,568.66
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-882,333.00	-882,333.00
Залруулсан					
Тайлант үеийн				268,360,153.01	268,360,153.01
Бусад дэлгэрэнгүй					
Өмчид гарсан	857,365,418.00			87,822,840.00	9451,188,258
Зарласан ногдол				-36,987,690	-36,987,690
Дахин үнэлгээний		-			-130,348,801.35
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	908,307,982.92	111,172,099.86	91,992,981.37	834,820,091.17	1,946,293,155.32
НББ-н бодлогын өөрчлөлтийн					
Залруулсан					
Тайлант үеийн				83,349,060.38	83,349,060.38
Бусад дэлгэрэнгүй					
Өмчид гарсан	5,410,794.70				5,410,794.70
Зарласан ногдол ашиг				-40,254,022.95	-40,254,022.95
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	913,718,777.62	111,172,099.86	91,992,981.37	877,915,128.60	1,994,798,987.45

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2020.02.13

Аудитын нэр:

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн

Аудитын код:

САГ-2020-/24/-СТА-ТӨҮГ

Шалгагдсан байгууллагын нэр:

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ

Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тусгай зөвшөөрөл олгох тушаалыг үндэслэн анхан шатны баримтгүйгээр ажил гүйлгээг бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.		Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	М.Түмэнжаргал Л.Балган
2	Хүлээн авалтын зардлыг үйл ажиллагааны зардлаар тооцон татвар ногдуулах орлогыг 26.0 сая төгрөгөөр бууруулсан нь "ААНОАТ-ын хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь заалт " Энэ хуулийн 8...-т заасан татвар ногдох орлогоос хуулийн 12 дугаар зүйлд заасан зардлыг хасч албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно" гэсэн заалтыг зөрчсөн байна.	26.0	Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	М.Түмэнжаргал Л.Балган
3	Иргэнд олгосон ибаримтаар зардал бүртгэж үйл ажиллагааны зардлыг 1.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь "Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь заалт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1.1	Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	М.Түмэнжаргал Л.Балган
4	Тухайн байгууллагын ажилтантай холбогдох шүүгчийн захирамжийн дагуу ажиллаагүй хугацаанд цалин олгож, түүнд ногдох НДШ-ийн төлбөрийг зардлаар тооцож хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зардлыг 7.4 сая төгрөгөөр өсгөсөн нь "Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалт "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.	7.4	Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	М.Түмэнжаргал Л.Балган
	ДҮН	34.5			

